

**тамга, тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих,
лавлагаа олгох журам**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад шинээр болон дахин тамга, тэмдгийн хяналтын дугаар /цаашид “хяналтын дугаар” гэх/ олгох бүртгэл хөтлөх, хяналтын дугаарыг хүчингүй болгох, улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах, тамга, тэмдэг хийлгэх захиалга өгөх, үйлдвэрлэх, тамга, тэмдэг үйлдвэрлэх этгээдээс тайлан ирүүлэх, тамга, тэмдгээ хураалгах, хураалгасан тамга, тэмдгийг төрийн архивт шилжүүлэн хадгалуулах, устгах, улсын бүртгэлийн мэдээллийн сангаас лавлагаа олгоход энэ журмыг баримтална.

1.2.Энэ журмын 1.1-т заасан тамга, тэмдэгтэй холбоотой үйл ажиллагааг **улсын** бүртгэлийн байгууллага хэрэгжүүлнэ.

1.3.Хяналтын дугаар дахин давтагдахгүй 10 оронтой тооноос бүрдсэн, улсын бүртгэлийн мэдээллийн сангаас олгосон дугаар байна. Хяналтын дугаарын эхний 2 тоо уг дугаарыг олгосон улсын бүртгэлийн байгууллагын бүртгэх код, дараагийн 2 тоо уг дугаарыг олгосон оны сүүлийн хоёр тоо, сүүлийн 6 тоо цахим мэдээллийн сангаас олгосон дугаарыг тус тус илэрхийлнэ.

1.4. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн тэмдэгт харьяалах байгууллагын нэр, регистрийн дугаар, нэгжийн нэр, тамга, тэмдгийн үйлдвэрийн код, хяналтын дугаар **тус тус** бичигдсэн байна.

1.5.Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 226 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-ын 2.1, 2.2-т заасан байгууллага тамга, тэмдэг, мөн журмын 2.3-т заасан байгууллага, хуулийн этгээд тэмдэг хэрэглэнэ.

1.6.Улсын бүртгэгч дараах хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад хяналтын дугаар олгоно:

1.6.1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газар;

1.6.2.олон улсын гэрээгээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага, түүний төлөөлөгчийн газар;

1.6.3.гадаадын хуулийн этгээд/компани, нөхөрлөл/-ийн төлөөлөгчийн газар;

1.6.4.улс төрийн нам, түүний дүрэмд заасан зохион байгуулалтын бүтцийн нэгж;

1.6.5.сууц өмчлөгчдийн холбоо;

1.6.6.Улсын Их Хуралд харьяалагддаг байгууллагын болон төрийн захиргааны төв байгууллагын харьяалах төсөл, хөтөлбөрийн нэгж;

1.6.7.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан хуулийн этгээдийн зохион байгуулалтын бүтцийн нэгж;

1.6.8.гадаадын ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар.

1.7.Тамга нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 226 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-ын 3.1-д заасан хэмжээ, бичээстэй байна.

1.8.Тамга хэрэглэх эрх бүхий төрийн байгууллагын тэмдэг нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 226 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-ын 3.2.1-д заасан хэмжээтэй, харьяалал, нэр, хяналтын дугаартай байна.

1.9.Тамга хэрэглэх эрхгүй байгууллага, хуулийн этгээдийн тэмдэг нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 226 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-ын 2.4, мөн журмын 3.2.2-т заасан хэлбэр, хэмжээ, бичээстэй байна.

1.10.Хуулийн этгээд тамга, тэмдгээ **хаяж** үрэгдүүлсэн тохиолдолд тухайн хуулийн этгээдийн эрх бүхий этгээд цагдаагийн байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

Хоёр.Хяналтын дугаар олгох ажиллагааны дараалал

2.1.Улсын бүртгэгч хяналтын дугаар шинээр болон дахин олгоход дараах дарааллыг баримтална:

2.1.1.цаасан болон цахим хэлбэрээр ирүүлсэн өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг нягтлан үзэж, хүлээн авах;

2.1.2.өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийн үнэн зөвийг нотлоход шаардагдах бусад баримтыг өргөдөл гаргагчаас гаргуулан авах;

2.1.3.өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг хуулийн этгээдийн цахим хувийн хэрэгтэй, шаардлагатай бол архивын эх нотлох баримт бичигтэй тулган нягталж, хяналтын дугаар олгох эсэхийг шийдвэрлэх;

2.1.4.хяналтын дугаар олгохоор шийдвэрлэсэн бол тухайн хуулийн этгээдийн нэр, хэлбэр, регистрийн дугаарын мэдээллийг улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь тамга, тэмдгийн хяналтын дугаарын бүртгэлийн сан /цаашид “хяналтын дугаарын бүртгэлийн сан” гэх/-д оруулах;

2.1.5.хяналтын дугаарын бүртгэлийн сангаас хэвлэсэн хяналтын дугаар бүхий маягтыг гарын үсэг, баталгааны тэмдгээр баталгаажуулж, өргөдөл гаргагчид батлагдсан маягтаар тэмдэглэл үйлдэн, гарын үсэг зуруулж, хүлээлгэн өгөх;

2.1.6.хяналтын дугаарын улсын бүртгэл хөтлөхөд үндэслэсэн өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг тухай бүр цахимжуулан, ажлын 5 өдрийн дотор улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн архивт шилжүүлж, тухайн хуулийн этгээдийн хувийн хэрэгт хавсаргах.

2.2.Улсын бүртгэгч Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9, 8.10 дахь хэсэгт заасан хугацаанд хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад хяналтын дугаарыг дахин олгоно.

Гурав.Улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл хүлээн авах

3.1.Хяналтын дугаарын улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг дараах этгээд цаасан, эсхүл цахим хэлбэрээр гаргана:

3.1.1.хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага;

3.1.2.хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч;

3.1.3.хоёр буюу түүнээс дээш үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчтэй хуулийн этгээдийн тухайд тогтоол, шийдвэрээр эрх олгогдсон этгээд;

3.1.4.итгэмжлэлээр эрх олгогдсон этгээд;

3.1.5.хуульд заасан эрх бүхий бусад этгээд.

3.2.Улсын бүртгэгч шаардлага хангасан өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг хүлээн авч, хуудсыг дугаарлана.

3.3.Улсын бүртгэгч цахим хэлбэрээр гаргасан өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг, улсын бүртгэлийн мэдээллийн сангаас тухайн бүртгэл хөтлөхөд шаардагдах мэдээллийг тус тус нягтлан үзэж, шаардлага хангасан тохиолдолд “Улсын бүртгэлд бүртгэх эсэх тухай цахим хэлбэрээр хариу өгөх мэдэгдэл /УБ-09 маягт/”-ийг ажлын 2 өдрийн дотор өргөдөл гаргагчид илгээнэ.

3.4.Цахим хэлбэрээр гаргасан өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэсэн тохиолдолд энэ журмын 3.1-д заасан этгээд эх нотлох баримтыг **улсын бүртгэлийн байгууллагад ажлын 5 өдрийн дотор хүргүүлнэ.**

Дөрөв.Улсын бүртгэл хөтлөх

4.1.Улсын бүртгэгч хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, түүний зохион байгуулалтын бүтцийн нэгжид шинээр болон дахин олгох хяналтын дугаарын улсын бүртгэл хөтөлнө.

4.2.Энэ журмын 1.6.1, 1.6.2, 1.6.3-т заасан шинээр байгуулсан хуулийн этгээд, олон улсын гэрээгээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага, түүний төлөөлөгчийн газар, гадаадын хуулийн этгээд/компани, нөхөрлөл/-ийн төлөөлөгчийн газарт тэмдгийн хяналтын дугаарыг баримт бичиг шаардахгүйгээр олгоно.

4.3.Тамга хэрэглэх эрх бүхий этгээдэд Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 226 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-ын 3.9-д заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас олгосон тамга шинээр хийлгэх зөвшөөрлийг үндэслэн тамганы хяналтын дугаар олгоно.

4.4.Энэ журмын 4.2-т зааснаас бусад хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, түүний зохион байгуулалтын бүтцийн нэгж шинээр олгох хяналтын дугаарыг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

4.4.1.энэ журмын 1.6.4-т заасан этгээдийн тухайд байгуулсан шийдвэр, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, тэмдэг хийлгэхийг зөвшөөрсөн тухай Улсын Дээд Шүүхийн албан бичиг;

4.4.2.энэ журмын 1.6.5-д заасан этгээдийн тухайд байгуулсан шийдвэр, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, тэмдэг хийлгэхийг зөвшөөрсөн тухай сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан бичиг;

4.4.3.энэ журмын 1.6.6-д заасан төсөл, хөтөлбөрийн нэгжийн тухайд тэмдэг хэрэглэхийг зөвшөөрсөн эрх бүхий этгээдийн тогтоол, тушаал, албан бичиг;

4.4.4.энэ журмын 1.6.7-д заасан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн тухайд тэмдэг хэрэглэхийг зөвшөөрсөн шийдвэр/тогтоол, тушаал, захирамж/, албан бичиг;

4.4.5.энэ журмын 1.6.8-д заасан этгээдийн тухайд байгуулсан шийдвэр, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, тэмдэг хийлгэхийг зөвшөөрсөн тухай гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан бичиг;

4.4.6.өргөдөл гаргагч гадаад улсын иргэн бол паспортын хуулбар;

4.4.7.итгэмжлэлээр эрх олгогдсон этгээдийн хувьд итгэмжлэл;

4.4.8.үйлчилгээний хөлс төлсөн баримт.

4.5.Энэ журмын 4.2, 4.4-т заасан хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, түүний зохион байгуулалтын бүтцийн нэгжид дахин олгох хяналтын дугаарыг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

4.5.1.тамганы хяналтын дугаарыг дахин олгоход энэ журмын 4.3-т заасан Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас олгосон тамга дахин хийлгэх зөвшөөрөл;

4.5.2.энэ журмын 1.6.4, 1.6.5, 1.6.8-д заасан хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, эрх бүхий этгээдийн шийдвэр, эсхүл тогтоол, улсын бүртгэлд бүртгэсэн байгууллагын тэмдэг дахин хийлгэхийг зөвшөөрсөн албан бичиг;

4.5.3.энэ журмын 4.4.6, 4.4.7, 4.4.8-д заасан баримт бичиг.

4.6.Ашиглах боломжгүйгээр элэгдэж хуучирсан, гэмтсэн, өнгө, загвар, хэлбэр болон хуулийн этгээдийн нэр, хэлбэр өөрчлөгдсөн тохиолдолд тухайн хуулийн этгээдийн тамга, тэмдэг, энэ журмын 4.5-д заасан баримт бичгийг хавсаргана.

4.7.Улсын бүртгэгч энэ журмын 4.6-д заасан хуулийн этгээдийн тамга, тэмдгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/55 дугаар тушаалын 8 дугаар хавсралтаар баталсан “Хураалгасан тамга, тэмдгийн тодорхойлолт /УБ-08 маягт/-ыг 2 хувь үйлдэж, нэг хувийг өргөдөл гаргагчид, нэг хувийг тухайн хуулийн этгээдээс ирүүлсэн баримт бичигт хавсаргана.

4.8.Хяналтын дугаарын улсын бүртгэлийг хүчингүйд тооцсон, тамга, тэмдгийг хүчингүй болгосон шүүхийн шийдвэрт энэ журмын 4.5-д заасан баримт бичгийг хавсаргана.

4.9.Хяналтын дугаарын улсын бүртгэлийг болон тамга, тэмдгийг хүчингүйд тооцсон хяналтын улсын байцаагчийн дүгнэлтэд энэ журмын 4.5-д заасан баримт бичгийг хавсаргана.

4.10.Тамга, тэмдэг устсан, эсхүл хаяж үрэгдүүлсэн тохиолдолд хяналтын дугаарыг хүчингүйд тооцсон хяналтын улсын байцаагчийн дүгнэлтэд энэ журмын 4.5-д заасан баримт бичгийг хавсаргана.

4.11.Хяналтын дугаар бүхий маягтыг хаясан, үрэгдүүлсэн тохиолдолд хяналтын дугаарын улсын бүртгэлийг хүчингүйд тооцсон хяналтын улсын байцаагчийн дүгнэлтэд энэ журмын 4.5-д заасан баримт бичгийг хавсаргана.

4.12.Улсын бүртгэгч шинээр болон дахин олгох хяналтын дугаарын улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэж, тухай бүр цахимжуулан, ажлын 5 өдрийн дотор улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн архивт хүлээлгэн өгнө.

Тав.Улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах

5.1.Улсын бүртгэгч дараах тохиолдолд хяналтын дугаарын улсын бүртгэлд бүртгэхээс татгалзана:

5.1.1.өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг шаардлага хангаагүй, бүрдэл дутуу;

5.1.2.энэ журмын 3.1-д заасан өргөдөл гаргах этгээдээс бусад этгээд өргөдөл гаргасан;

5.1.3.эрх бүхий этгээдийн шийдвэр болон хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн хяналтын дугаарын улсын бүртгэлийг түдгэлзүүлсэн;

5.1.4.өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг хуурамчаар үйлдсэн.

5.2.Улсын бүртгэгч энэ журмын 5.1-д заасан үндэслэлээр хяналтын дугаарын улсын бүртгэлийг түдгэлзүүлэхдээ эрх бүхий этгээдийн шийдвэр, хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэж, тухай бүр цахимжуулан, ажлын 5 өдрийн дотор улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн архивт хүлээлгэн өгнө.

5.3.Хяналтын дугаарын улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан үндэслэл арилсан тохиолдолд улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг дахин гаргаж болно.

Зургаа.Тамга, тэмдэг хийлгэх захиалга өгөх, үйлдвэрлэх

6.1.Тамга, тэмдэг үйлдвэрлэх этгээд Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр тамга, тэмдэг хийлгэх захиалга авах, үйлдвэрлэх үйл ажиллагааг эрхэлнэ.

6.2.Тамга, тэмдэг үйлдвэрлэх этгээд улсын бүртгэлийн байгууллагаас олгосон хяналтын дугаар бүхий маягтыг үндэслэн энэ журмын 3.1-д заасан этгээдээс тамга, тэмдэг хийлгэх захиалгыг хүлээн авна.

6.3.Тамга, тэмдэг үйлдвэрлэх этгээд улсын бүртгэлийн гэрчилгээний нүүрэн талын баруун дээд өнцөгт тамга, тэмдэг үйлдвэрлэсэн тухай тэмдэглэгээг хийнэ.

6.4.Тамга, тэмдэг үйлдвэрлэх этгээд тамга, тэмдэг хийлгэх захиалга өгөөгүй байхад улсын бүртгэлийн гэрчилгээн дээр тэмдэглэгээ хийхийг хориглоно.

6.5.Тамга, тэмдэг үйлдвэрлэх этгээд шаардлага хангасан тамга, тэмдгийг үйлдвэрлэн, тухайн тамга, тэмдгийн дардас, захиалгын мэдээллийг баталгаажуулан бүртгэл хөтөлж, цахим тайлангийн системд оруулна.

Долоо.Тамга, тэмдэг үйлдвэрлэх этгээдээс тайлан ирүүлэх

7.1.Улсын бүртгэлийн байгууллага шинээр болон дахин хяналтын дугаар олгох бүртгэл хөтлөх, хяналтын дугаарыг хүчингүй болгох, тамга, тэмдэг үйлдвэрлэх этгээдтэй мэдээлэл солилцох, тайлан ирүүлэхэд цахим тайлангийн систем ашиглана.

7.2.Тамга, тэмдэг үйлдвэрлэх этгээд улсын бүртгэлийн байгууллагад тамга, тэмдэг үйлдвэрлэсэн тайланг цаасан болон цахим хэлбэрээр сар бүрийн сүүлчийн ажлын өдрөөр тасалбар болгон гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор ирүүлэх бөгөөд тайланд үйлдвэрийн албан бичиг, үйлдвэрлэсэн тамга, тэмдгийн жагсаалт, хяналтын дугаар бүхий маягтын буцах хэсгийг хавсаргана.

7.3.Улсын бүртгэгч энэ журмын 7.2-т заасны дагуу цаасан хэлбэрээр ирүүлсэн тайланг тухай бүр архивын хадгаламжийн нэгж болгон дараа сарын 20-ны өдрийн дотор улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн архивт хүлээлгэн өгнө.

7.4.Улсын бүртгэгч энэ журмын 7.2-т заасны дагуу цахим хэлбэрээр ирүүлсэн тайланг нэгтгэн дараа сарын 20-ны өдрийн дотор улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн архивт хүлээлгэн өгнө.

Найм.Хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага тамга, тэмдгээ хураалгах

8.1.Энэ журмын 1.6-д заасан хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, хувьчлагдсан, дампуурсан, хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа зогссон үндэслэлээр улсын бүртгэлээс хасагдсан бол улсын бүртгэгчид тамга, тэмдгээ хураалгана.

8.2.Тамга, тэмдэг устсан, эсхүл хаяж үрэгдүүлсэн, тамга, тэмдгийг хүчингүй болгосон, хүчингүйд тооцсон үндэслэлээр дахин хяналтын дугаар олгосны дараа тамга, тэмдэг олдвол хэрэглэхгүй бөгөөд улсын бүртгэгчид хураалгана.

8.3.Улсын бүртгэгч энэ журмын 8.1, 8.2-т заасан хураалгасан тамга, тэмдгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/55 дугаар тушаалын 8 дугаар хавсралтаар баталсан “Хураалгасан тамга, тэмдгийн тодорхойлолт /УБ-08 маягт/”-ыг 2 хувь үйлдэж, нэг хувийг өргөдөл гаргагчид, нэг хувийг тухайн хуулийн этгээдээс ирүүлсэн баримт бичигт хавсаргаж, хадгалалт, хамгаалалтын шаардлага хангасан сейф, шүүгээнд хадгална.

8.4.Улсын бүртгэгч хураалгасан тамга, тэмдгийн тодорхойлолт, холбогдох баримт бичгийг тухай бүр цахимжуулан, тухайн хуулийн этгээдийн хувийн хэрэгт хавсаргахаар ажлын 5 өдрийн дотор улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн архивт хүлээлгэн өгнө.

Ес.Хураалгасан тамга, тэмдгийг шилжүүлэн хадгалуулах

9.1.Улсын бүртгэлийн байгууллага Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 226 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-ын 6.17-д заасны дагуу мөн журмын 2.1.1-2.1.10-т заасан байгууллагын хураалгасан тамга, тэмдгийг Үндэсний төв архивт, мөн журмын 2.1.11, 2.1.12, 2.1.15-д заасан байгууллагын хураалгасан тамга, тэмдгийг тухайн аймаг, нийслэлийн төрийн архивт хайрцаг, иш, дардасыг салгалгүйгээр дараа оны 1 дүгээр сард багтаан тус тус шилжүүлэн хадгалуулна.

Арав.Хяналтын дугаарыг хүчингүй болгох

10.1.Хяналтын дугаарыг дараах тохиолдолд хүчингүйд тооцсон хяналтын улсын байцаагч дүгнэлт гаргана:

10.1.1.тамга, тэмдэг устсан, эсхүл хаяж үрэгдүүлсэн;

10.1.2.хяналтын дугаар бүхий маягтыг хаясан, үрэгдүүлсэн.

10.2.Энэ журмын 1.6-д заасан хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын эрх бүхий этгээд хяналтын дугаарыг хүчингүй болгуулахаар улсын бүртгэлийн байгууллагын хяналтын улсын байцаагчид хүсэлт гаргаж, доорх баримт бичгийг хавсаргаж ирүүлнэ.

10.2.1.энэ журмын 10.1.1-д заасан тохиолдолд тухайн хуулийн этгээдийн эрх бүхий этгээдийн шийдвэр, өдөр тутмын сонинд зарлуулсан зар;

10.2.2.энэ журмын 10.1.2-т заасан тохиолдолд тухайн хуулийн этгээдийн эрх бүхий этгээдийн шийдвэр, өдөр тутмын сонинд зарлуулсан зар, тамга, тэмдэг хийлгээгүй тухай лавлагаа;

10.2.3.хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч гадаад улсад бүртгэлтэй бол улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрмийн хуулбар;

10.2.4.энэ журмын 1.10-т заасны дагуу бүртгүүлсэн тодорхойлолт.

Арван нэг.Хураалгасан тэмдгийг устгах

11.1.Энэ журмын Есдүгээр зүйлд заасны дагуу шилжүүлэн хадгалуулснаас бусад хураалгасан тэмдгийг устгах ажлыг хагас жил тутамд Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэл хариуцсан нэгжид хураалгасан тэмдгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар, нийслэлд хураалгасан тэмдгийг Нийслэл дэх Улсын бүртгэлийн газрын даргын тушаалаар, аймагт тухайн аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус тус зохион байгуулна.

11.2.Энэ журмын 11.1-д заасан ажлын хэсэг тус бүр хураалгасан тэмдгийг устгасан тухай ажлын тайлан, холбогдох баримтыг архивын хадгаламжийн нэгж болгуулахаар нийслэлд улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн архивт, аймагт тухайн аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн архивт тус тус хүлээлгэн өгнө.

Арван хоёр.Тамга, тэмдгийн талаарх лавлагаа олгох

12.1.Улсын бүртгэгч улсын бүртгэлийн мэдээллийн сангаас тамга, тэмдгийн талаарх лавлагааг энэ журмын 3.1-д заасан этгээдийн бичгээр гаргасан хүсэлт, улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс төлсөн баримтад үндэслэн ажлын 3 өдрийн дотор олгоно.

12.2.Улсын бүртгэгч олгосон тамга, тэмдгийн лавлагааны талаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/55 дугаар тушаалын 10 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, баримт бичгийг хүлээлгэн өгсөн тэмдэглэл /УБ-10 маягт/”-ийг хөтөлж, хуудас дууссан болон тухайн оны сүүлчийн өдрөөр тасалбар болгон хааж, улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн архивт хүлээлгэн өгнө.

12.3.Улсын бүртгэгч энэ журмын 1.6.1-1.6.3, 1.6.6, 1.6.7-д заасан хуулийн этгээдийн тамга, тэмдгийн лавлагаа олгосон тухай баримт бичгийг тухай бүр хуулийн этгээдийн цахим мэдээллийн санд оруулан “Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн баримт бичгийг архивт шилжүүлсэн жагсаалт”-аар ажлын 5 өдрийн дотор улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн архивт хүлээлгэн өгнө.

12.4.Улсын бүртгэгч энэ журмын 1.6.4, 1.6.5, 1.6.8-д заасан хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын тамга, тэмдгийн лавлагаа олгосон тухай баримт бичгийг улирал бүр архивын хадгаламжийн нэгж болгон, дараа сарын 5-ны өдрийн дотор улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн архивт хүлээлгэн өгнө.

Арван гурав.Бусад

13.1.Тамга, тэмдэг үйлдвэрлэх этгээд энэ журмыг зөрчвөл тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгуулах тухай саналыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

---oO---